**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 10 сарын 18 өдөр Дугаар А/53 Улаанбаатар хот

Нийслэлийн иргэдийн спортын
VI наадмын ширээний шагайн наадгайн шигшээ
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн иргэдийн спортын VI наадмын Ширээний шагайн наадгайн шигшээ тэмцээнийг 2017 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр “Буянт-Ухаа” спортын ордонд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.360.000 /Нэг сая гурван зуун жаран мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Б.Түвшинбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

1116128787 9077448

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны ...10 дугаар...сарын ...18...-ны өдрийн
А/63 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Нийслэлийн иргэдийн спортын
VI наадмын ширээний Шагайн наадгайн шигшээ
тэмцээн зохион байгуулах төсөв

| № | Зардлын нэр | Нийт дүн /төг/ |
|---|---|---|
| 1. | Тамирчдын шагнал:<br>15 х 20.000 төг = 300.000 төг<br>15 х 16.000 төг = 240.000 төг<br>15 х 12.000 төг = 180.000 төг | 720.000 |
| 2. | Шүүгчдийн ажлын зардал:<br>/5 хүн х 1 өдөр х 20.000 төг/ | 100.000 |
| 3. | Өргөмжлөл | 50.000 |
| 4. | Медаль<br>45ш х 10.000=450.000 төг | 450.000 |
| 5. | Анонс, цом | 40.000 |
| **ДҮН:** | | **1.360.000** |

Боловсруулсан: Б.Түвшинбаяр
Хянасан: О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн
А/53 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1116128787 9077448

Нийслэлийн иргэдийн спортын
VI наадмын ширээний шагайн наадгайн шигшээ
тэмцээн шүүгчдийн бүрэлдэхүүн

| | | |
|---|---|---|
| 1. | Ерөнхий шүүгч | Б.Арслан |
| 2. | Нарийн бичиг шүүгч | Б.Нарантуяа |
| 3. | Шүүгч | Б.Доржсүрэн |
| 4. | Шүүгч | Д.Долгорсүрэн |
| 5. | Шүүгч | Э.Энхсайхан |